



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 31 өдөр

Дугаар А/304

Мөрөн сум

Малын гоц халдварт өвчний  
дархлаажуулалтын ажлыг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын “Шүлхий өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/165 дугаар тушаалын хүрээнд шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг аймгийн хэмжээнд бүх үхэр, гахай, цаа бугыг хамруулан 2024 оны 08 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 22 хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.


2. Дархлаажуулалтын арга хэмжээний ажлын хэсгийг шуурхай зохион байгуулан шаардагдах ажиллах хүн хүч, шатахуун, автомашинаар ханган явц, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Дархлаажуулалтад шаардагдах вакциныг сумдад хуваарилан, болзошгүй мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, гүйцэтгэлийн явцад хяналт тавьж, тайлан мэдээг холбогдох газарт хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Л.Ариунаа)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газар (Б.Батбилгүүнд)-т үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Захирамж2024

6712011183